

Research article

## Хэл ба нийгмийн харилцан холбоо

Батмөнхийн Чимэг-Эрдэнэ<sup>\*1</sup> , Үүрэгийн Ариунболд<sup>2</sup> 

<sup>\*1</sup>Монгол Улсын Боловсролын их сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Монгол хэлний тэнхимийн докторант, Улаанбаатар, Монгол Улс

<sup>2</sup>Монгол Улсын Боловсролын их сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Монгол хэлний тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор, Улаанбаатар, Монгол Улс

### ARTICLE INFO

#### History.

Received: 28 March, 2025

Revised: 09 June, 2025

Published: 05 June, 2026

#### Түлхүүр үг:

Нийгэм хэл шинжлэл,  
оюутан, уялдаа

### ABSTRACT

Хэл ба нийгмийн харилцан холбоог онолын болон эмпирик түвшинд авч үзэх нь нийгэм хэл шинжлэлийн судалгааны үндсэн чиглэлүүдийн нэг юм. Энэхүү судалгаанд хэл ба нийгмийн харилцан хамаарал, тэдгээрийн бие биедээ үзүүлэх нөлөөллийг цогцоор нь судлан шинжилсэн болно. Онолын түвшинд хэл нь нийгмийн харилцааг илэрхийлэх, зохицуулах, дамжуулах үүрэг бүхий нийгмийн чухал үзүүлэлт бол эмпирик түвшинд тухайн нийгмийн бүлэг, давхарга, нас, боловсролын ялгаа зэрэг хүчин зүйлс хэлний хэрэглэнд хэрхэн нөлөөлж буйг бодиг жишээ, баримтаар илрүүлдэг. Хэлний хөгжил, өөрчлөлт нь нийгмийн бүтэц, эдийн засаг, улс төр, соёлын орчны өөрчлөлттэй салшгүй холбоотой байдаг. Нийгмийн орчин өөрчлөгдөхийн хэрээр хэлний хэрэглээ, хэл зүйн хэлбэр, үгийн сан шинэчлэгдэн баяжихын зэрэгцээ зарим уламжлалт хэрэглээ хумигдах хандлага ажиглагддаг. Судалгааны хэсэгт их, дээд сургуулийн оюутан залуусын хэлний хэрэглээ, хандлагыг тодорхойлох зорилгоор асуулгын аргыг ашигласан. Судалгаанд оролцогчдын өдөр тутмын харилцаанд хэрэглэж буй хэлний хэлбэр, гадаад үгийн хэрэглээ, цахим орчин дахь хэлний онцлог, эх хэлдээ хандах хандлага зэрэг үзүүлэлтүүдийг хамруулан судалсан болно. Үүний үр дүнд орчин үеийн залуусын хэлний хэрэглээ нь уламжлалт болон орчин үеийн нөлөөллийн хөгжлийн дунд оршиж байна. Даяаршил, олон улсын соёлын урсгал, цахим мэдээллийн нөлөө нь залуу үеийн хэлний сонголт, хэрэглэнд хүчтэй нөлөөлж байгаа нь илэрхий байна. Түүнчлэн нийгмийн өөрчлөлт, даяаршлын үйл явц, мэдээлэл, харилцаа холбооны технологийн хурдацтай хөгжил нь хэлний хэрэглээ, үгийн сангийн бүрэлдэхүүн, хэлбэр зүйд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг. Ялангуяа цахим орчин, сүлжээний хэрэглээ нэмэгдэхийн хэрээр товчилсон хэллэг, гадаад үгийн шууд болон дам хэрэглээ, холимог хэллэгүүд идэвхжиж, хэлний шинэ хэв маяг бүрэлдэн тогтож байна.

© 2026, Author(s). This is an open access article under the CC BY-04 license (<https://creativecommons.org/licenses/by/4.0/deed.en>)

### Оршил

Хэл бол бидний бодол санааг илэрхийлж, нийгмийн харилцааг бий болгодог үндэс суурь билээ. Хүн бүр хэлээр дамжуулан мэдээлэл солилцож, мэдрэмжээ илэрхийлж, өөрийгөө тодорхойлж, нийгмийн байр сууриа тогтоодог тул хэл нь нийгмийн зохицуулалт, таних тэмдгийн чухал хэсэг болдог. Хэл ба нийгэм нь салшгүй холбоотой, харилцан нөлөөлөх шинжтэй цогц үзэгдэл юм. Нэг талаас тухайн нийгмийн соёл, үнэт зүйлс, сэтгэлгээ, түүхэн хөгжлийг илэрхийлэгч чухал систем болдог. Нөгөө талаас нийгмийн бүтэц, харилцаа, орчин нөхцөл нь хэлний хэрэглээ, хөгжил, өөрчлөлтөд шууд нөлөөлдөг. Эрдэмтэн William Bright “Нийгэм хэл шинжлэлийн үүрэг нь хэл ба нийгмийн бүтцийн хамтын хувьслыг судлахад оршино” (Bright, 1966, p. 13) хэмээн үзсэн байна.

Нийгэм хэл шинжлэлийн үүднээс авч үзвэл хэлний хэрэглээ нь нас, хүйс, боловсрол, мэргэжил, нийгмийн давхарга, газар зүйн байрлал зэрэг олон хүчин зүйлээс хамаарч өөр өөр хэлбэрээр илэрдэг.

Жишээлбэл, залуусын хэл ярианд шинэ үг хэллэг, товчлол, гадаад үгийн хэрэглээ давамгайлах хандлагатай байхад ахмад үеийнхний дунд уламжлалт, хүндэтгэлийн өнгө аястай хэллэгийг илүү хэрэглэдэг. Мөн хэл нь нийгмийн харилцааг зохицуулах чухал хэрэгсэл бөгөөд хүндэтгэл, ёс зүй, харилцааны хэв маягийг илэрхийлэх үүрэгтэй. Тухайлбал, монгол хэлний хүндэтгэлийн утгат нэгжүүд нь хүний нас, зэрэг зиндаа, харилцааны ойр дотно байдлаас шалтгаалан сонгогдон хэрэглэгддэг нь нийгмийн харилцааны бүтэцтэй шууд холбоотойг харуулдаг. Нөгөө талаас нийгмийн өөрчлөлт, технологийн хөгжил, даяаршил зэрэг нь хэлэнд шинэ үг хэллэг нэвтрэх, хэрэглээний хэлбэр өөрчлөгдөхөд нөлөөлж байна. Ялангуяа цахим орчны харилцаа нь хэлний товчлол, холимог хэрэглээг нэмэгдүүлж, хэлний уламжлалт хэв маягт тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.

Нийгэм хэл шинжлэл нь хувь хүний элемент, нийгмийн орчин зэрэг хүчин зүйлийг нэмэн судалснаараа хэл бол хөдлөнгүй, чөлөөтэй систем болохыг баталсан юм. “Хэл нь нийгмийн орчинд хэрэглэгддэг, нийгэмтэй салж болшгүй харьцаатай, хэл нь нийгмийн хөгжлийг даган тасралтгүй хувирч хөгжиж байдаг”.

Хэл нь зөвхөн харилцааны хэрэгсэл төдийгүй нийгмийн бүтэц, соёл, боловсролын орчинтой салшгүй холбоотой. Хэлний хэрэглээ нь нийгмийн байр суурь, боловсролын түвшин, соёлын үнэт зүйлсийг дамжуулах гол хэрэгсэл юм. (Saussure, 1916, pp. 2-203)

Хэл нь соёлын үнэт зүйлсийг дамжуулах гол хэрэгсэл. Бичиг үсэг, ардын зүйр цэцэн үг, ёс заншлын утга агуулга нь хэлний ачаар ард түмний дунд уламжлагдан үлддэг. Жишээ нь, гэр бүлийн яриа, ардын үлгэр домог нь хүүхдэд ёс суртахууны хандлага, нийгмийн дүрэм журмыг зааж өгдөг. Үүний үр дүнд хэл нь нийгмийн нэгдмэл байдлыг бий болгох чухал хүчин зүйл болдог.

Хэл нь эрх мэдэл, статусыг илэрхийлэх хэрэгсэл болдог. Албан ёсны баримт бичиг, хууль эрх зүйн хэллэг, шинжлэх ухааны нэр томъёо нь тухайн бүлгийн мэргэжлийн стандарт, нэвтрэх боломжийг тодорхойлдог. Олон улсад англи хэлний ур чадвартай байх нь ажил эрхлэх болон боловсролд илүү боломж олгодог жишээ бий. Иймээс тодорхой хэлний мэдлэггүй байх нь нийгмийн боломжуудаас хоцрох эрсдэл дагуулдаг байна.

Цахим (дижитал) технологийн нөлөөгөөр хэлний хэрэглээ хурдтай өөрчлөгдөж байна. Богино бичлэг, цахим бичвэрийн товчлол, холимог хэлээр бичих зэрэг шинэ хэлбэрүүд гарч ирж, залуусын харилцааны хэв маягийг өөрчилж байна. Энэ нь хэлний хурд, товчлол, шинэ үг хэллэг үүсэхэд хүргэж байгаа ч ойлголтын зөрчил, буруу мэдээлэл тархах боломж, хэлний хэл зүйн асуудлыг нэмэгдүүлж байна.

Америкийн нийгэм судлаач, эрдэмтэн William Labov \1927\ нь орчин үеийн нийгмийн хэл шинжлэлд хамгийн их нөлөөтэй эрдэмтэн гэж тооцогддог. Тэрээр хэрэглээний хэлнээс мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх зэрэг орчин үеийн аргачлалыг бий болгосон эрдэмтэн билээ. Тэрээр “Хэл нь хэлний хэлбэлзэл болон өөрчлөлтийн эх сурвалж юм гээд хэлний дотоод хүчин зүйлсийг судлан үзнэ. Өөрчлөлт шинийг санаачлагчдын нийгмийн байр, нийгэм эдийн засгийн анги, хөрш, яс үндэс, жендэрийн үүрэг, хэлний өөрчлөлтийг удирдагчид, дамжуулах, өсгөх, өөрчлөлтийн үргэлжлэл, Нийгэм хэл шинжлэл хэлийг нийгмийн хам орчинд судална. Нийгэм судлаачдад хэл нийгмийн янз бүрийн үйл явцыг бүртгэх мэдрэмтгий багаж шиг хэрэгтэй. Өгүүлэгчийн нийгмийн байр суурь өөрчлөгдөхөд түүний хэл хурдан өөрчлөгддөг. Хэлний энэхүү хөдлөнгө шинж түүнийг нийгэмд гарсан өөрчлөлтийг илрүүлэгч болгон өргөн ашиглах үндэс болно” (Labov, 2019, p. 641)

Хэл нь нийгмийн харилцааг бүрдүүлж, соёл, эрх мэдэл, мэдээлэл дамжуулах зэрэг олон талыг тодорхойлдог. Орчин үеийн сорилтуудыг даван туулахын тулд хэлний олон төрөлт, хэлний эрх тэгш байдал, боловсролд анхаарах хэрэгтэй. Ингэснээр хэл нь хүмүүсийг холбох, харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэх болон нийгмийн оролцоог дээшлүүлэх хүч хэвээр байх болно.

Иймээс хэл ба нийгмийн харилцан холбоог судлах нь тухайн нийгмийн хөгжлийн чиг хандлага, соёлын өөрчлөлт, хэлний дархлаа, бодлогыг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

## Судалгааны арга зүй

Энэхүү судалгаа нь хэл ба нийгмийн харилцан хамаарлыг нийгэм хэл шинжлэлийн үүднээс тодорхойлох зорилготой бөгөөд чанарын болон тоон судалгааны аргыг хослуулан хэрэглэв. Судалгааны хүрээнд онолын болон хэрэглээний түвшний мэдээллийг нэгтгэн боловсруулж, дүн шинжилгээ хийсэн болно.

Эмпирик судалгааны хүрээнд асуулга, ярилцлага, ажиглалтын аргуудыг хэрэглэв. Асуулгын аргаар оюутан, суралцагчдын хэлний хэрэглээ, хандлага, нийгмийн орчны нөлөөллийг тодорхойлж, тоон мэдээлэл цуглуулсан. Харин ярилцлагын аргаар оролцогчдын хэлний хэрэглээний шалтгаан, хандлагын гүнзгийрүүлсэн мэдээллийг авч, чанарын шинжилгээ хийв.

Цуглуулсан мэдээлэлд статистик болон агуулгын шинжилгээ (content analysis)-ний аргыг хэрэглэж, өгөгдлийг нэгтгэн дүгнэв. Тоон мэдээллийг хувь, давтамж, харьцааны үзүүлэлтээр боловсруулж, чанарын мэдээллийг ангилан бүлэглэж, утга агуулгын хувьд тайлбарлан дүгнэсэн болно.

## Үндсэн хэсэг

Энэ нь хоёр талт, харилцан хамааралтай үйл явц юм. Нийгмийн хөгжил, өөрчлөлт нь хэлний үгийн сан (шинэ нэр томъёо, гадаад үг), хэрэглээ (цахим хэл, товчлол), хэв маяг (албан ба албан бус хэл), хэл зүй (зөв бичих дүрэм, бүтээврийг хэрэглэхгүй байх) зэрэгт шууд нөлөөлдөг. Тодруулбал,

- Нийгмийн хөгжил, технологи, цахим хөгжил: Нийгмийн хөгжлөөр шинэ ухагдахуун, техник технологи нэвтрэхэд тухайн нэрлэлт даган орж ирдэг жамтай. Сүүлийн үед нийгмийн хөгжил хурдтай байх нөхцөлөөс тэдгээр үгс ч олон тоогоор орж ирэв. “чатлах”, “постлох”, “принтерлэх” зэрэг үгсээс гадна хүүхэд залуусын дунд тоглоом, үйл ажиллагаатай нь холбоотой “тилтрэх tilt”, “нокрох knock”, “GG” зэрэг үгс түгээмэл хэрэглэгдэж, энгийн хэллэг дундаа ч оруулах болжээ. Жишээлбэл, “дүнгээ гаргах гэж тилтэрлээ, өлсөөд Жижи болох гэж байна, өө алхаж ирээд нокрохоо шахлаа” гэх мэт шинэ үг, хэрэглээ бий болж байна.
- Даяаршил: Англи буюу даяаршлын хэлний хүчтэй нөлөө нэмэгдэж байна. Оюутнуудын дунд түгээмэл хэрэглэгдэж буй гадаад үгсэд нийгэмд тогтсон нэр томъёоноос ангид, ярианы түвшний үгс зонхилж байна. Тухайлбал, *care, engaged, complain, flirt, impossible, unbelieve, GG* зэрэг үгсийг монгол хэлний өгүүлбэрийн бүтцэд шууд оруулан хэрэглэх явдал элбэг байна. Энэ нь хэлний хэм хэмжээ, найруулгын хувьд зөрчил үүсгэхээс гадна үгийн утгын нарийвчлал, илэрхийллийн оновчтой байдалд сөргөөр нөлөөлөх магадлалтай. Ийм төрлийн хэл хольж хэрэглэх үзэгдэл нь нэг талаас даяаршил, цахим харилцаа, гадаад хэлний нөлөөлөлтэй холбоотой боловч нөгөө талаас эх хэлний мэдлэг, үгийн баялаг, хэлний боловсрол хангалтгүй байгааг илтгэх үзүүлэлт гэж үзэх үндэслэлтэй. Харин монгол хэлэнд аль хэдийн утга, хэрэглээ нь төлөвшсөн үг байсаар байхад түүнийг орлуулах зорилгоор харь үгийг шууд авч хэрэглэх нь хэлний хэм хэмжээ, найруулгын хувьд зохимжгүй юм. Тухайлбал, “халамжлах” гэсэн үгийн оронд “careлэх”, “манарах”, “тогтворгүй болох” зэрэг утгыг илэрхийлэх боломжтой байхад “tilтрэх” гэх мэт хэллэг хэрэглэх нь хэлний баялаг, илэрхийллийн оновчтой байдлыг сулруулж байна. “Тилтрэх” (tilt) гэх үг нь монгол хэлний “хазайх” гэсэн утгатай ойролцоо боловч гадаад хэлний хэрэглээнд өөр утгын хүрээнд ашиглагддаг. Тухайлбал, tilt нь (ялангуяа цахим тоглоомын орчинд) тоглогч ялагдах, эсвэл тоглоолтын явцад сэтгэлзүйн хувьд тогтворгүй болж, бухимдах, уурлах зэрэг сэтгэлзүйн хариу үйлдлийг илэрхийлэхэд хэрэглэгддэг. Сүүлийн үед монгол залуус уг үгийг шууд орчуулгагүйгээр “тилтрэх” хэлбэрээр хэрэглэх болсон нь утгын ялгааг бүдгэрүүлж, монгол хэлний үгийн сангийн хэм хэмжээ, найруулгад сөргөөр нөлөөлөх хандлагатай байна. Энэ нь гадаад үгийг зохисгүйгээр шууд авч хэрэглэх явдал хэлний баялаг, илэрхийллийн оновчтой байдлыг алдагдуулах нэг хэлбэр болохыг харуулж байна. Эндээс нэгэн чухал дүгнэлтийг

гаргаж болно. Харь хэлний үг аливаа хэлний үгийн сан, ялангуяа үйл үгийн санд идэвхтэй нэвтрэн орж, төрөлх хэлний үгсийг орлох хандлага давамгайлах нь тухайн хэлний хэрэглээний доройтол, цаашлаад мөхөх эрсдэлийн нэг илрэл гэж үзэх үндэслэлтэй.

- Нийгмийн бүтэц: Нийгмийн тогтолцоон дахь элементүүдийн хоорондох анги болон нийгмийн бусад бүлгийн харилцаа, хөдөлмөрийн хуваарь, нийгмийн байгууллын шинж, эдгээрээр нөхцөлдсөн тогтвортой дэглэмжсэн холбоо (Literature, 2016) Нийгмийн бүтцийн үндсэн элементүүд нь бүлэг: Гэр бүл, найз нөхөд, ажлын хамт олон гэх мэт хүмүүсийн бүлэглэлүүд, институт: Боловсрол, гэр бүл, эдийн засаг, улс төр, шашин гэх мэт нийгмийн тогтолцоонууд, давхарга: Эдийн засаг, боловсрол, эрх мэдэл зэргээр ялгаатай нийгмийн хэсгүүд, байр суурь, үүрэг: Хүн бүрийн нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг зэрэг нь элементүүдийн харилцан уялдаа, зохион байгуулалт нь нийгмийн бүтцийг бүрдүүлдэг. Нийгмийн бүтцэд нөлөөлөх хэлний асуудлыг авч үзвэл, ахмад хүнд хүндэтгэлийн хэлээр, найз нөхөдтэйгөө энгийн, дотно хэлээр, албан байгууллагад албан ёсны хэлээр харилцах гэх мэт харилцаа үүсдэг бөгөөд бидний асуулга судалгаагаар энэхүү байдал ажиглагдсан.

William Labov нийгмийн хүчин зүйлс (нас, анги давхарга, орчин) нь хэлний хувьсал, хэлбэлзлийн гол шалтгаан гэдгийг туршилтаар нотолсон нь нийгэм хэл шинжлэлийн онол, арга зүйд чухал нөлөөтэй байдаг.

Хэл нийгэмд нөлөөлөх нь сэтгэлгээ төлөвшүүлэх, үнэт зүйл дамжуулах, эрх мэдэл, нөлөөлөл бий болгох чухал хэрэгсэл болдог. Жишээлбэл: Улс төрийн хэл нь олон нийтэд хүчтэй нөлөөлж, үзэл бодлыг нь өөрчилдөг байна. Боловсролын хэл нь нийгмийн мэдлэг, чадамжийн түвшинд нөлөөлдөг хүчин зүйл билээ. Нийгэм хэл шинжлэлийн судлагдахуунд хүмүүсийн хэлний хэрэглээ, нийгмийн бүлгийн харилцаанаас гадна нийгэмд хөшүүргэ болдгоороо хэлний бодлого, төлөвлөлт, хэрэгжүүлэгч хөдөлгүүр болдгоороо оюун санаанд нөлөөлөгч хэлний боловсрол зэрэг нь маш чухал юм. Эрдэмтдийн судалгаагаар хэлний боловсрол нь суралцагчдын танин мэдэхүй, нийгмийн идэвх, соёлын эрх мэдэлд нөлөөлдөг. Монгол хэлний боловсролын орчин, сургалтын хөтөлбөр, багшийн арга барил нь хэлний хэрэглээ, түгээмэл байдлыг тодорхойлдог гол хүчин зүйл байна. Хүүхдийн танин мэдэхүй нь нийгмийн харилцан үйлчлэл, тэмдэг, хэл, соёлыг сурах явцаар хөгждөг байна.

Мөн хүндэтгэлийн хэл нь нийгмийн харилцааг зохицуулж, эерэг харилцааг бий болгодог. Америкийн эрдэмтэн Walt Wolfram: “Хэл бол нийгмийн хамгийн хүчирхэг тэмдгийн нэг юм. Хэлээр дамжуулан бид хэн болох, хаанаас ирсэн, хэнтэй харьцах талаарх нийгмийн чухал мэдээллийг солилцож чаддаг. Хүний зан чанар, хүсэл эрмэлзэл, бодлыг ганц хоёр үгээр мэдэх боломжтой.” Мөн хэл нь нийгэмд хүч, эрх мэдэл, ялгаатай байдлыг бий болгох чухал хүчин зүйл юм. (Wolfram, 1969, p. 249)

Үүнээс дүгнэвэл, хэл ба нийгмийн харилцаа нь нэг чиглэлтэй бус, харин харилцан нөлөөлөх диалектик шинжтэй юм. Нийгмийн өөрчлөлт хэлэнд шинэчлэл авчирдаг бол хэл нь нийгмийн сэтгэлгээ, бүтэц, харилцаанд нөлөөлж байдаг.


### **Судалгааны илрэл**

Хэл ба нийгмийн харилцан холбоог илрүүлэхийн тулд нийгмийн нэг бүлгээр төлөөлөн судалж үзэв. Нийгмийн тэрхүү бүлэг нь нийгмийн идэвхтэй гишүүн болох оюутан залуус юм. Монгол улсын нийт хүн ам 3,5 сая давснаас 15-29 хүртэлх насны 739095 байна. (National Statistical Office of Mongolia, 2024) Энэ нь монгол хэлээр хэрэглэгчдийн дийлэнх нь залуу үеийнхэн бөгөөд нийгмийн хэлний хэрэглээг төлөөлж чадахуйц гэж үзэж байна.

Судалгааны явцад цуглуулсан өгөгдөлд үндэслэн их, дээд сургуулийн оюутан, суралцагчдын монгол хэлний хэрэглээ, хандлагын онцлог, нийгмийн хүчин зүйлсийн нөлөөллийг дүн шинжилж гаргав. Судалгаанд асуулгын аргыг ашигласан бөгөөд үүний үр дүн дараах байдлаар илрэв.

Энэхүү асуулгын судалгаанд нийт 270 оюутан оролцсон ба хүчин төгөлдөр асуулгын хуудас нийт 257. Үүнд, судалгаанд хамрагдсан сургуулиуд: СЭЗИС, МУИС, МУБИС, ДХИС, ГЭБДС зэрэг багтана. Харин судалгаанд оролцогчдыг курсээр нь авч үзэхэд дийлэнх хувь нь 1-р курсийн оюутан болно.

1-р график. Судалгаанд хамрагдсан сургууль, курс



1.1-р хүснэгт. Асуултын уялдаа хамааралд хийсэн анализ

Analysis	Variables	Statistic	p-value	Interpretation
ANOVA (сургууль)	Сурах сонирхол ~ Сургууль	F = 1.41	0.196	Ялгаа байхгүй
ANOVA (сургууль)	Бичих чадвар~ Сургууль	F = 3.35	0.001	Ялгаа байна
Chi-square	Сургууль × Чөлөөт цаг	$\chi^2 = 955.25$	< .001	Хамаарал байна
Correlation	Сонирхол × ЭЕШ-ын оноо	r = 0.18	0.045	Сул эерэг хамаарал
Correlation	Бичих чадвар × ЭЕШ-ын оноо	r = 0.11	0.223	Хамааралгүй
Correlation	Хичээлийн багц цаг × ЭЕШ-ын оноо	r = -0.11	0.216	Хамааралгүй
ANOVA (Course)	Сонирхол ~ Хичээлийн багц цаг	F = 1.70	0.187	Ялгаа байхгүй
ANOVA (Course)	Бичих чадвар ~ Хичээлийн багц цаг	F = 0.46	0.629	Ялгаа байхгүй

Энэхүү судалгаанд нийт 270 оюутан хамрагдсан бөгөөд үр дүнгээс харахад их дээд сургуулийн оюутнуудын монгол хэлний чадвар, хандлагыг тодорхойлох гол хүчин зүйл нь хичээлийн багц цаг бус, харин сургалтын орчин буюу сургууль өөрөө болох нь тодорхой байна. Тодруулбал, сургуулиудын хооронд бичих чадварын (эсээ бичиж чадах эсэх) хувьд статистикийн ач холбогдолтой ялгаа илэрсэн ( $F = 3.35$ ,  $p = 0.001$ ) нь тухайн сургуулийн сургалтын чанар, арга зүй бодит чадварт нөлөөлж байгааг харуулж байна.

Харин монгол хэл сурах сонирхлын (монгол хэлний хичээлд дуртай эсэх) хувьд сургуулиудын хооронд ялгаа илрээгүй ( $F = 1.41$ ,  $p = 0.196$ ). Мөн сонирхол (монгол хэлний хичээлд дуртай эсэх) болон ЭЕШ-ын онооны хооронд сул боловч статистикийн ач холбогдолтой эерэг хамаарал илэрсэн ( $r = 0.18$ ,  $p = 0.045$ ) бол оюутнуудын өөрийн үнэлсэн бичих чадвар болон ЭЕШ-ын онооны хооронд хамаарал илрээгүй ( $r = 0.11$ ,  $p = 0.223$ ).

Үүнтэй адил хичээлийн багц цагийг хангалттай гэж үзэх үнэлгээ нь ЭЕШ-ын оноотой статистикийн хувьд хамааралгүй байсан ( $r = -0.11$ ,  $p = 0.216$ ).

Чөлөөт цагийн хэв маяг нь сургуулиас хамааралтай байгааг Chi-квадрат шинжилгээ харуулсан ( $\chi^2 = 955.25$ ,  $p < 0.001$ ). Харин курсийн ялгааны хувьд монгол хэл сурах сонирхол (эх хэлээ сурах дуртай эсэх) ( $F = 1.70$ ,  $p = 0.187$ ), бичих чадвар (эсээ бичих чадварын үнэлгээ) ( $F = 0.46$ ,  $p = 0.629$ ), хичээлийн багц цагийн үнэлгээ ( $F = 1.74$ ,  $p = 0.180$ ) зэрэг үзүүлэлтүүдэд статистикийн ач холбогдолтой ялгаа илрээгүй.

Дэлгэрэнгүй тайлбарлавал, бичих чадвар нь сургуулиас хамааралтай болох нь тогтоогдсон ( $F = 3.35$ ,  $p = 0.001$ ). Өөрөөр хэлбэл, суралцагчдын бичгийн чадвар нь сурч буй сургуулийн онцлогтой, нарийвчилбал мэргэжлийн онцлогтой холбогдоно.

Мөн Chi-square шинжилгээний үр дүнгээс харахад сургууль болон чөлөөт цагийн ашиглалтын хооронд статистикийн ач холбогдол бүхий хамаарал байна ( $\chi^2 = 955.25$ ,  $p < .001$ ). Энэ нь суралцагчдын чөлөөт цагаа өнгөрүүлэх хэлбэр нь сургуулийн орчин, соёлтой холбоотой байж болохыг харуулж байна. Корреляцийн шинжилгээний хувьд:

- Сурах сонирхол ба ЭЕШ-ын оноо хооронд сул эерэг хамаарал ( $r = 0.18$ ,  $p = 0.045$ ) илэрсэн нь сонирхол нэмэгдэхийн хэрээр шалгалтын оноо бага зэрэг өсөх хандлагатайг илтгэнэ.
- Харин бичих чадвар ба ЭЕШ-ын оноо ( $r = 0.11$ ,  $p = 0.223$ ), хичээлийн багц цаг ба ЭЕШ-ын оноо ( $r = -0.11$ ,  $p = 0.216$ ) хооронд статистикийн ач холбогдол бүхий хамаарал илрээгүй байна.

Түүнчлэн хичээлийн багц цаг нь: сурах сонирхолд ( $F = 1.70$ ,  $p = 0.187$ ), бичих чадварт ( $F = 0.46$ ,  $p = 0.629$ ) нөлөөлөхүйц ялгаа үүсгэхгүй байгааг ANOVA шинжилгээ харуулж байна.

Иймээс энэхүү судалгаа нь хэлний боловсролын үр дүнг хичээлийн багц цагаар илүүтэйгээр сургалтын орчин, институцийн онцлог тодорхойлж байгааг харуулж байна.

## Чанарын судалгааны асуултын анализ

1-р зураг. Асуулт 2 (Эх хэлний хичээлд дуртай/дургүй байх шалтгаан)



## Асуулт 2 (Эх хэлний хичээлд дуртай/дургүй байх шалтгаан)

Оюутнуудын хариултад “сонирхолтой”, “дуртай” зэрэг үгс өндөр давтамжтай илэрсэн нь эх хэлний хичээлд эерэг хандлага давамгайл байгааг харуулж байна. Үүний зэрэгцээ “зөв”, “сурах” зэрэг үгсийн хэрэглээ нь уг хичээлийг хэлний зөв хэрэглээг эзэмших хэрэгсэл гэж ойлгож байгааг илтгэнэ. Иймд оюутнууд эх хэлний хичээлийг сонирхлын болон хэрэглээний хос шинжтэйгээр хүлээн авч байна.

2-р зураг. Асуулт 4 (ЕБС-аас эзэмшсэн мэдлэг, чадвар)



**Асуулт 4 (ЕБС-аас эзэмшсэн мэдлэг, чадвар)**

“бичих”, “зөв”, “эсээ”, “дүрэм” зэрэг үгс давамгайлалтай илэрсэн нь бичгийн болон дүрмийн мэдлэгийг чухалчилсан сургалтын үр дүнг харуулж байна. Оюутнууд ЕБС-ийн эх хэлний хичээлээр голчлон зөв бичих, найруулан бичих чадвар эзэмшсэн гэж үзжээ.

3-р зураг. Асуулт 7 (Ирээдүйн хэрэглээ, ач холбогдол)



**Асуулт 7 (Ирээдүйн хэрэглээ, ач холбогдол)**

“албан”, “эргөдөл”, “ажил” зэрэг үгс өндөр давтамжтай гарсан нь эх хэлний чадварыг ажлын байртай холбон ойлгож байгааг харуулж байна. Оюутнууд эх хэлний мэдлэгийг албан бичиг боловсруулах, ажил мэргэжилд ашиглах хэрэгсэл гэж үзэж байна.

4-р зураг. Асуулт 8 (Хэлний бодлого, хууль тогтоомжийн мэдлэг)



**Асуулт 8 (Хэлний бодлого, хууль тогтоомжийн мэдлэг)**

“мэдэхгүй” гэсэн хариулт хамгийн өндөр давтамжтай гарсан нь оюутнуудын хэлний бодлогын талаарх мэдлэг хангалтгүй байгааг илтгэнэ. Зарим хариултад “хууль”, “биелэлт” зэрэг ойлголт дурдагдсан ч тэдгээрийн агуулга тодорхой бус байна.


5-р зураг. Асуулт 10 (Хувь хүний оролцоо)



### Асуулт 10 (Хувь хүний оролцоо)

“зөв”, “ярьж”, “бичиж” зэрэг үгс давамгайлж байгаа нь оюутнууд өөрсдийн оролцоог зөв ярьж, зөв бичихтэй холбон ойлгож байгааг илтгэнэ. Ихэнх нь хэлний зөв хэрэглээг хадгалах нь хувь хүний үндсэн үүрэг гэж үзжээ. Харин хэлний хөгжилд бүтээлч, соёлын түвшинд хувь нэмэр оруулах ойлголт бараг илрээгүй байна.

6-р зураг. Асуулт 11 (Хэлний орчны нөлөө)



### Асуулт 11 (Хэлний орчны нөлөө)

“нөлөөлдөг”, “буруу”, “алдаатай” зэрэг үгсийн давтамж өндөр байгаа нь оюутнууд хэлний буруу хэрэглээг анзаарч байгааг харуулж байна. Зарим нь буруу хэллэг нь сөрөг нөлөө үзүүлнэ гэж үзсэн бол нөгөө хэсэг нь өөрсдөө ялгаж чаддаг тул нөлөөлөхгүй гэж үзжээ. Иймээс хэлний орчны нөлөөллийн талаарх ойлголт оюутнуудын дунд ялгаатай байна.

Эдгээр дүн шинжилгээ нь их, дээд сургуулийн оюутан, суралцагчийн монгол хэлний хэрэглээний бодит байдал, хэлний хандлагын онцлог, нийгмийн хүчин зүйлстэй уялдаа холбоог харуулж байгаа бөгөөд дээд боловсролын салбарт хэрэгжүүлж буй хэлний бодлого, сургалтын хөтөлбөртэй холбоотой дүгнэлт гаргахад чухал үндэс болно.

### Дүгнэлт

Хэл ба нийгмийн харилцан холбоо нь хоёр талт, харилцан нөлөөлөх шинжтэй цогц үзэгдэл болох нь энэхүү судалгаагаар батлав. Хэл нь нийгмийн харилцааг зохицуулах, соёлын үнэт зүйлсийг дамжуулах, хувь хүний нийгмийн байр суурийг илэрхийлэх чухал хэрэгсэл бөгөөд нийгмийн өөрчлөлт, хөгжилтэй уялдан тасралтгүй хувьсан өөрчлөгдөж байдаг.

Судалгааны үр дүнгээс харахад:

- Оюутнуудын хэлний чадварт сургалтын орчин илүү нөлөөтэй
- Хэлний хэрэглээнд даяаршил, цахим орчны нөлөө хүчтэй
- Эх хэлний хичээлд эерэг хандлага давамгайл

- Хэлний бодлогын талаарх мэдлэг сул түвшинд байна

Иймээс:

- Хэлний боловсролын чанарыг сайжруулах
- Эх хэлний зөв хэрэглээг төлөвшүүлэх
- Хэлний бодлогын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх
- Цахим орчны хэлний хэрэглээнд анхаарах шаардлагатай байна.

Хэл бол нийгмийн хөгжил, соёлын дархлаа, оюуны үнэт зүйлийг хадгалагч гол хүчин зүйл мөн тул хэл ба нийгмийн харилцааг цаашид гүнзгийрүүлэн судлах нь чухал ач холбогдолтой юм.

## Language and Social Interrelation

Chimeg-Erdene Batmunkh<sup>\*1</sup>  Ariunbold Uureg<sup>2</sup> ,

<sup>\*1</sup>*Ph.D. candidate, Department of Mongolian Language, School of Social Sciences and Humanities, Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia*

<sup>2</sup>*Ph.D, Associate Professor, Department of Mongolian Language, School of Social Sciences and Humanities, Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia*

**Abstract:** The study of the relationship between language and society at both theoretical and empirical levels is one of the fundamental directions in sociolinguistic research. This study comprehensively examines the interdependence between language and society, as well as their mutual influences. At the theoretical level, language is considered an important social phenomenon that serves the functions of expressing, regulating, and transmitting social interactions. At the empirical level, it identifies, through concrete examples and data, how factors such as social groups, social stratification, age, and educational differences influence language use. The development and change of language are closely connected with transformations in social structure, economy, politics, and cultural contexts. As the social environment changes, language use, grammatical forms, and vocabulary are renewed and enriched, while certain traditional usages tend to decline. In the empirical section of the study, a questionnaire method was employed to determine the language use and attitudes of university students. The research covered indicators such as the forms of language used in daily communication, the use of foreign words, linguistic features in digital environments, and attitudes toward the native language. The findings reveal that contemporary youth language use exists at the intersection of traditional and modern influences. It is evident that globalization, international cultural flows, and digital information environments strongly affect the language choices and practices of young people. Furthermore, social changes, globalization processes, and the rapid development of information and communication technologies have a significant impact on language use, vocabulary composition, and linguistic structures. In particular, with the increasing use of digital platforms and online networks, abbreviated expressions, direct and indirect borrowings from foreign languages, and hybrid forms of language are becoming more active, leading to the emergence of new linguistic patterns.

**Keyword:** *Sociolinguistics, student, correlation*

## Reference

- Bright, W. (1966). *Sociolinguistics*. Mouton.
- Labov, W. (1994). Principles of linguistic change. *Volume I: Internal factors (Language in Society 20)*., 641.
- Labov, W. (2001). Principles of Linguistic Change. *Volume II: Social Factors*, 498-518.
- Labov, W. (2010). Principles of Linguistic Change, Volume 3. *Language in Society 39*.  
<https://doi.org/10.1002/9781444327496>
- Labov, W. (2019). The Social Stratification of English in New York City. In Nansalma.N, *Sociolinguistics* (p. 27). Ulaanbaatar.
- Literature, I. o. (2016). Dictionary of the Mongolian Language. Ulaanbaatar.
- National Statistical Office of Mongolia. (2024, 06 10). Ulaanbaatar.
- Saussure, F. d. (1916). *Course in general linguistics*. McGraw-Hill.
- Wolfram, W. (1969). Linguistic correlates of social differences in the Negro Community. *Georgetown Monograph Series on Languages and Linguistic NO.22*, 249.